

Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал ба эцэг эхчүүдийн боловсролын түвшний холбоо хамаарлын судалгаа

Жин Минг*

Өвөр Монголын Өөртөө Засах Орон

Хураангуй

Энэ судалгаанд судлаач чеклист ба асуулгын аргаар 5-6 насны 105 Монгол хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг бие бялдар, танин мэдэхүй ба нийгэмшихүй гэх гурван талаас судлан, үүнд сургуульд бэлтгэгдсэн байдлыг хүүхдийн эцэг эхчүүдийн боловсролын түвшинтэй авч судалсан. судалгааны үр дүнд: хүүхдийн нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд эцгийн боловсролын түвшинтэй сөрөг холбоо хамаарлын хандлагатай ($F=3.414, P=0.037^*$) үр дүнд хүрсэн байна. Хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдал нь эхчүүдийн боловсролын түвшний хувьд ялгаатай, эхчүүдийн боловсролын түвшин өндөр болох тусам хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдал нь сайн ($F=3.139, p=0.048^*$) байна. Энэ нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал нь түүний эцэг эхийн боловсролын түвшинтэй холбоо хамааралтай байхыг тодорхойлов.

Түлхүүр үг

5-6 насны хүүхэд, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүй

Удиртгал

Судлаачийн хувьд хүүхдийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг гурван талаас судлах болно. Нэгдүгээр нь бие бялдарын сургуульд бэлтгэгдсэн байдал: алхалт бүхий хөдөлгөөн зөв цэгцтэй байх, гар хурууны хэсгийн нарийн хөдөлгөөн зөв оновчтой байх, хувь хүний ариун цэврийг эрхэмлэх зэрэг агуулга багтана. Хоёрдугаарт, танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдал: үг яриа, тоон тоолол, хэмжээ (олон цөөн, том жижиг) харьцуулал, хэлбэр, орон зайны танин мэдэхүй, нийгмийн танин мэдэхүй, физикийн танин мэдэхүй, цагийн дарааллын танин мэдэхүй, бичиж сурах анхны танин мэдэхүй. Гуравдугаарт, нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдал: өөрийн мэдрэмж, сэтгэлийн хөдөлгөөнөө үг, үйл хөдлөлөөр илэрхийлэх, нийгмийн хэв зурмыг дагах, зөв харилцааны соёлын хандлагатай байх, ёс суртахууны анхны танилтай байх, сурах дур сонирхолтой байх.

Судлагдсан байдал

Эцэг, эхчүүдийн боловсролын түвшин нь хүүхдийн бага боловсролын дэвшилт ба хүүхдийн танин мэдэхүйн хөгжилтийг нөлөөлнө гэж судлаач Ганзак тодорхойлов (Ганзак³³, 2000, х.419). Э.Хоффийн судалгааны үр дүнд хүүхдийн танин мэдэхүйн хөгжилтийг нөлөөлөх гэр бүлийн орчны нэгэн элемент нь эцэг эхчүүдийн

боловсролын түвшин болно, боловсролын түвшин өндөртэй эцэг эхчүүд хүүхдэдээ оюунлаг хөгжлийн боломжийг хангаж өгдөг (Хофф³⁴, 2003a, х.147; Хофф, 2003b, х.1368). Ардила нарын судалгааны үр дүнд тэдгээр өндөр боловсролтой эцэг эхчүүдийн хүүхдүүд харьцангуй элбэг баялаг үгсийн сантай бөгөөд хэл ярианы хурд их, танин мэдэхүйн тестийн дүнгийн хувьд өндөр оноотой байна (Ардила³⁵, нар, 2005, х.539). Өндөр боловсролтой эхчүүдийн хүүхдийн танин мэдэхүйн талаарх сургуульд бэлтгэгдсэн байдал нь боловсролын түвшин харьцангуй доор байгаа эхчүүдийн хүүхдүүдээс илүү өндөр байхын шалтгаан нь хүүхэд хэлд орох явцын дунд шууд нөлөө үзүүлэх хүн бол эх хүн болно, үг хэл эзэмших явц мөн хүний танин мэдэхүйн бий болох явц мөн, тийм учраас эх хүн хүүхдээ хөхүүлж өсгөхдөө байнга нялах хүүхэдтэй хэлж, ярилцаж байгаа нь харахдаа хэдийгээр нэг их утга учиргүй шиг байсан ч түүний чанаа нүсэр их шинжлэх ухааны утга учиртай байлаа. Бедарын судалгааны үр дүнд эхчүүдийн боловсролын түвшин нь хүүхэд насны эрт үеийн үсэг бичгийн мэдлэг эзэмшихийг чадварыг нөлөөлнө гэв (Бедар³⁶ 1993, х.815). Дээд боловсролтой эхчүүд хувьд хүүхэдтэйгээ харьцангуйгаар байнга харилцдаг бөгөөд хүүхдэдээ илүү үлгэр ном уншиж өгдөг, тийм учраас ерөнхий боловсролтой

³⁴ E Hoff

³⁵ Ardila, Rosselli, Matute, & Guajardo

³⁶ Nazli Baydar

*Холбоо барих зохиогч: 563299001@qq.com

³³Ganzach

эхчүүдээс илүү сайн байдаг гэж үздэг (Хофф-Гинсбэрг³⁷, 1991, х.782) .

Судалгааны арга зүй

Тус судалгаанд хэрэгжүүлсэн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын тухай асуулга нь Японы ядуурлыг бууруулах сангийн тушаалтаар хийгдсэн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг байцаах чеклистийг ашиглав. Үүнд хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг бие бялдар, танин мэдэхүй ба нийгэмшихүй зэрэг гурван талыг судалсан байна. Үүний дагуу хүүхдийн ээж аав буюу шууд асрагчаас үндсэн мэдээллийг цуглуулж, судалгаандаа ашигласан байна. Судалгаанд цуглуулсан тоо баримтыг SPSS программаар анализ хийсэн.

Үүнд Улаанбаатар хотын Яармагийн 229 дүгээр цэцэрлэг, МУБИС-ын 249 дүгээр цэцэрлэг, МУБИС-ын 87 дүгээр цэцэрлэг, хотын захын цэцэрлэгт Цэнгэлтэй дүүргийн бдүгээр хорооны 221 дүгээр цэцэрлэг ба 246 дүгээр цэцэрлэгийн нийт 105 хүүхэд ба тэд нэрийн шууд асрагч (эцэг, эхчүүд) тус удааны судалгаанд оролцсон байна.

Судалгааны үр дүн

Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг бие бялдар, танин мэдэхүй ба нийгэмшихүйн талаар шалган байцаах чеклист буюу “5 настай хүүхдийн даалгавар (61-72сар)” нь тус судалгаанд хэрэгжүүлсэн байна. Үүнд бие бялдар нь 6 сэдэв, танин мэдэхүйд 9 сэдэв, нийгэмшихүйд 7 сэдэв. Тус шалгуурын оноо өгөх баримжаа Нэг даалгавар бүрэн зөв биелүүлсэн бол 2 оноо, хагас биелүүлсэн байвал 1 оноо, биелүүлж чадахгүй бол 0 оноо. Тиймээс нийт оноо нь 44. Нэг судлаач, нэг хүүхдийн хэлбэрээр цэцэрлэгийн тусгай хангаасан өрөөнд 30 min хугацаанд тус чеклистын судалгааг хийсэн байна. Туршилтын явцад шаардах хэрэгсэл метр, өнгөт зураг, 20 cm диаметртэй бөмбөг, 30 cm үржих 30 cm хэмжээтэй жижиг самбар, 10 ш шагай, үдээсний загвартай самбар зэргийг ашиглав.

Шалгуурын найдварт чанар

Энэхүү чеклистийг ашиглан сургуульд бэлтгэгдсэн байдлыг судлахдаа тус чеклистийн reliability ба validity-ийг шалгав. Үүнд тус шалгуурын Cronbach's α коэффициент 0.78, энэхүү тоо баримт нь шалгуурыг өргөнөөр хэрэгжүүлэх шаардлагад нийцэв.

Хүснэгт 1

Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын чеклистийн найдварт чанар

	Бие бялдар	Танин мэдэхүй	Нийгэм- шихүй	Нийт
Cronbach's α	.004	.345	.418	.544
Хуваар шалгуур ба ерөнхий шалгуурын хоорондох холбоо хамаарал	.586**	.738**	.755**	

Тайлбар: $p < 0.01$ статистик холбогдол бүхий ялгаатай утга


Энэхүү тоо баримт нь 5-6 насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэн бодитой харуулж чадна гэснийг тодорхойлжээ.

Эцэг эхчүүдийн боловсролын түвшин ба хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын холбоо хамаарал

Тус судалгаанд хамрагдсан хүүхдийн эцэг эхчүүдийн хүчин төгөлдөр бүхий үндсэн мэдээлэл нийт 96 хувь. Үүнд ерөнхий боловсролтой нь 53 хүн, нийт хүний тооны 55% эзэлнэ, дээд боловсролтой нь 35 хүн, нийт хүний тооны 36%-ыг эзэлнэ, магистр буюу докторын түвшинтэй нь 8 хүн, нийт хүний 9%-ыг эзэлнэ.

Зураг 1

Эцгийн боловсролын түвшний байдал



Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал нь Эцгийн боловсролын түвшний хувьд ялгаатай байх эсэхийг тоон үзүүлэлтээр хүснэгт 2 мэт үзүүлсэн байна.

³⁷Hoff-Ginsberg

Хүснэгт 2


Эцгийн боловсролын түвшин ба хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал

ANOVA АНАЛИЗ						
		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Бие бялдар	Between Groups	.62	2	.313	.362	.697
	Within Groups	80.33	93	.864		
	Total	80.96	95			
Танин мэдэхүй	Between Groups	2.05	2	1.025	.412	.663
	Within Groups	231.28	93	2.487		
	Total	233.33	95			
Нийгэмшихүй	Between Groups	10.37	2	5.198	3.414	.037*
	Within Groups	141.60	93	1.523		
	Total	152.00	95			
Нийт	Between Groups	31.95	2	15.974	1.958	.147
	Within Groups	758.54	93	8.156		
	Total	790.49	95			

Тайлбар:** $p < 0.01$ * $p < 0.05$ статистик холбогдол бүхий ялгаатай утга

Зураг 2

Эцгийн боловсролын түвшин



Зураг 2-т хүүхдийн бие бялдарын талаар сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд эцгийн боловсролын түвшин харьцангуй доор болох тусам хүүхдийн бие бялдарын бэлтгэлийн оноо өндөр байдаг, гэвч энэ нь статистикийн утга бүхий ялгаатай байх стандартад хүрээгүй.

Хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд дээд боловсролтой хүүхдийн танин мэдэхүйн бэлтгэлийн оноо хамаг өндөр байж, дараалбал ерөнхий боловсролтой эцгийн хүүхэд, танин мэдэхүйн бэлтгэлийн хувьд хамаг доор оноотой байгаа хүүхдүүдийн эцэг нь магистр буюу докторын түвшинтэй байдаг, энэ нь судлаачийн урьдчилан тавьсан таамаглалтай зөрөөтэй, гэвч энэ үр дүн нь статистикийн утга бүхий ялгаатай байх стандартад хүрээгүй, үр дүнгийн шалтгааныг тооцвол: судалгаад хамрагдсан эцгүүд магистр буюу докторын хэмжээний боловсролын түвшинтэй хүний тоо зөвхөн 8 байж, сорьцын хувьд бага болохоор дээрх үр дүн ажиглагдаж байна. Нийгэмшихүйн хувьд эцгийн боловсролын түвшин өндөр болох тусам хүүхдийн нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын оноо нь харьцангуй доор байдаг. Энэ нь статистикийн утгын хувьд ялгаатай байна.

Хүснэгт 3

Хүүхдийн боловсролын түвшин ба эцгийн сургуульд бэлтгэгдсэн байдал

Multiple Comparisons								
Dependent Variable		(I) ETSB	(J) ETSB	Mean Difference (I-J)	Std. Error	Sig.	95% Confidence Interval	
							Lower Bound	Upper Bound
Бие бялдар	LSD	E(Ерөнхий)	D	.08895	.20243	.661	-.3130	.4909
			M/D	.28538	.35252	.420	-.4147	.9854
	D(Дээд)	E	-.08895	.20243	.661	-.4909	.3130	
		M/D	.19643	.36422	.591	-.5268	.9197	
	M/D	E	-.28538	.35252	.420	-.9854	.4147	
		D	-.19643	.36422	.591	-.9197	.5268	

Танин мэдэхүй	LSD	E(Ерөнхий)	D	-.22642	.34348	.511	-.9085	.4557
			M/D	.27358	.59815	.648	-.9142	1.4614
		D(Дээд)	E	.22642	.34348	.511	-.4557	.9085
			M/D	.50000	.61800	.421	-.7272	1.7272
		M/D	E	-.27358	.59815	.648	-1.4614	.9142
			D	-.50000	.61800	.421	-1.7272	.7272
Нийгэм- шхүй	LSD	E(Ерөнхий)	D	.28140	.26876	.298	-.2523	.8151
			M/D	1.20283*	.46803	.012	.2734	2.1323
		D(Дээд)	E	-.28140	.26876	.298	-.8151	.2523
			M/D	.92143	.48356	.060	-.0388	1.8817
		M/D	E	-1.20283*	.46803	.012	-2.1323	-.2734
			D	-.92143	.48356	.060	-1.8817	.0388
Нийт	LSD	E(Ерөнхий)	D	.27601	.62204	.658	-.9592	1.5113
			M/D	2.14387	1.08325	.051	-.0073	4.2950
		D(Дээд)	E	-.27601	.62204	.658	-1.5113	.9592
			M/D	1.86786	1.11919	.098	-.3546	4.0903
		M/D	E	-2.14387	1.08325	.051	-4.2950	.0073
			D	-1.86786	1.11919	.098	-4.0903	.3546

Тайлбар:** $p < 0.01$ * $p < 0.05$ статистик холбогдол бүхий ялгаатай утга


Үүнд боловсролын түвшний гурван хэмжээний хувьд ямар ялгаатай байхыг SPSS ийн ANOVA F тестийн LSD хоёр хоёр хэмжээсээр харьцуулах тестээр (хүснэгт 3) адилтгасны үр дүнд ерөнхий боловсролын түвшинтэй эцгүүдийн хүүхэд нь магистр буюу докторын боловсролын түвшинтэй эцгүүдийн хүүхдийн нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлаас сайн байна.

Нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд эцгийн боловсролын түвшин ялгаатай байх нь бодит байдалд нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хуваар тестийн 2дугаар даалгаварт (хүмүүс дэлгүүрт юм худалдаж авахаар дараалалд зогсож байгаа зургийг хүүхдэд үзүүлээд зураг дээр болж байгаа үйлдлийн зөв буруу эсэхийг хүүхдээс асууна) илэрсэн байдаг. Үүнд: ерөнхий боловсролтой эцгийн онооны дундаж хэмжээ нь 1.92, магистр буюу докторын түвшний эцгийн онооны дундаж тоон үзүүлэлт нь 1.50, статистикийн ялгаа зөрөө нь 0.425, $p = 0.032^*$.

Эхчүүдийн хувьд тус судалгаанд хамрагдсан хүчин төгөлдөр бүхий үндсэн мэдээлэл нийт 97 хувь. Үүнд ерөнхий боловсролтой нь 44 хүн, нийт хүний тооны 45% эзэлнэ, дээд боловсролтой нь 42 хүн, нийт хүний тооны 43%-ыг эзэлнэ, магистр буюу докторын түвшинтэй нь 11 хүн, нийт хүний 12%-ыг эзэлнэ.

Зураг 3


Эхийн Боловсролын түвшний Байдал



Эхчүүдийн боловсролын түвшний хувьд хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал ямар байхыг доорх (зураг 3) тоон үзүүлэлтээр харуулав.

Зураг 4

Эхийн боловсролын түвшин



Хүснэгт 4

Эхийн боловсролын түвшин ба хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал

ANOVA анализ		Sum of Squares	df	Mean Square	F	Sig
Бие Бялдар	Between Groups	.46	2	.228	.260	.772
	Within Groups	82.43	94	.877		
	Total	82.89	96			
Танин мэдэхүй	Between Groups	14.61	2	7.306	3.139	.048*
	Within Groups	218.75	94	2.327		
	Total	233.36	96			
Нийгэмшихүй	Between Groups	2.62	2	1.310	.821	.443
	Within Groups	149.94	94	1.595		
	Total	152.56	96			
Нийт	Between Groups	10.71	2	5.355	.641	.529
	Within Groups	784.84	94	8.349		
	Total	795.55	96			

Тайлбар:**p<0.01 *p<0.05 статистик холбогдол бүхий ялгаатай утга

Зураг 4-өөс хүүхдийн бие бялдрын сургуульд бэлтгэгдсэн байдал нь эхчүүдийн боловсролын түвшний хувьд илэрхий ялгаагүй. Нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд гурван төрлийн боловсролын түвшинд ялгаа зөрөөтэй, энэ нь эхчүүдийн боловсролын түвшин өндөр болох тусам хүүхдийн нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын онооны тоон үзүүлэлт харьцангуй доор байна гэсэн үг, гэвч статистикийн утга бүхий ялгаатай байхын стандартад хүрээгүй. Эхчүүдийн боловсролын түвшин хувьд хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын дундаж оноо нь статистикийн хувьд ялгаатай байна. (Хүснэгт 5) Үүнд хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд дээд боловсролтой эхчүүдийн хүүхдүүдийн танин мэдэхүй нь ерөнхий боловсролтой эхчүүдийн хүүхдээс харьцангуй өндөр байлаа. Хүснэгт 2-7 д (дээд-ерөнхий mean difference=.78, $p=.02<.05$), гэвч магистр докторын түвшинтэй эхчүүдийн хүүхдүүдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын тоон үзүүлэлтийн хувьд хамаг доор байдаг. Энэхүү тоон үзүүлэлтийн ялгаа зөрөө доорх мэт: дээд боловсролтой ба ерөнхий боловсролтой эхчүүдийн хувьд хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдал нь статистикийн

утга бүхий ялгаа зөрөөтэй байна.

Энэхүү ялгааг тодорхойлбол: танин мэдэхүйн хуваар тестийн 2 асуулт: хүүхдээс түүний нэр, нас, гэр бүлийн гишүүний тухай асуусан байдлын тоон үзүүлэлт нь ерөнхий боловсрол ба магистр докторын түвшинтэй эхчүүдийн хувьд статистикийн ялгаа зөрөөтэй (ерөнхий боловсролын дундаж хэмжээ=2.00, магистр доктор дундаж хэмжээ=1.91, дундаж зөрөө=0.091, $p=0.007^{**}$) Дээд боловсрол ба магистр докторын түвшинтэй эхчүүдийн хувьд бас адилхан зөрөөтэй байна (дээд боловсролын дундаж хэмжээ=2.00 магистр, доктор дундаж хэмжээ=1.91, дундаж зөрөө=0.091, $p=0.008^{**}$). 4 асуулт: олон цөөнийг харьцуулах даалгавар нь ерөнхий ба дээд боловсролын түвшинтэй эхчүүдийн хувьд статистикийн ялгаатай (дээд боловсролын дундаж хэмжээ=1.88, ерөнхий боловсролын дундаж хэмжээ=1.64 дундаж зөрөө= 0.245 $p=0.016^{*}$). 5 асуулт: үндсэн өнгө буюу завсрын өнгийг ялгах даалгаварт эхчүүдийн боловсролын түвшний ялгаа зөрөөгөөс болж тус даалгаврын онооны байдал нь статистикийн ялгаатай (дээд боловсролын дундаж хэмжээ=1.98, ерөнхий боловсролын дундаж хэмжээ=1.77, дундаж зөрөө=0.203, $p=0.012^{*}$)

Хүснэгт 5

Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал ба эхийн боловсролын түвшин

Multiple Comparisons							
Dependent Variable	(I) EBT	(J) EBT	M e a n Difference (I-J)	Std. Error	Sig.	95% Interval L o w e r Bound	Confidence U p p e r Bound
Бие бялдар	LSD	E(Ерөнхий)	D	-.14502	.20201	.475	-.5461
			M/D	-.09091	.31567	.774	-.7177
		D(Дээд)	E	.14502	.20201	.475	-.2561
			M/D	.05411	.31717	.865	-.5756
		M/D	E	.09091	.31567	.774	-.5359
			D	-.05411	.31717	.865	-.6839
Танин мэдэхүй	LSD	E(Ерөнхий)	D	-.78139*	.32908	.020	-1.4348
			M/D	-.77273	.51424	.136	-1.7938
		D(Дээд)	E	.78139*	.32908	.020	.1280
			M/D	.00866	.51669	.987	1.0345
		M/D	E	.77273	.51424	.136	-.2483
			D	-.00866	.51669	.987	-1.0345
Нийгэмшхүй	LSD	E(Ерөнхий)	D	.10173	.27245	.710	-.4392
			M/D	.54545	.42574	.203	1.3908
		D(Дээд)	E	-.10173	.27245	.710	-.6427
			M/D	.44372	.42777	.302	-.4056
		M/D	E	-.54545	.42574	.203	-1.3908
			D	-.44372	.42777	.302	-1.2931
Нийт	LSD	E(Ерөнхий)	D	-.55087	.62334	.379	-1.7885
			M/D	.38636	.97406	.693	1.5476
		D(Дээд)	E	.55087	.62334	.379	-.6868
			M/D	.93723	.97868	.341	1.0060
		M/D	E	-.38636	.97406	.693	-2.3204
			D	-.93723	.97868	.341	-2.8804

Тайлбар:**p<0.01 *p<0.05 статистик холбогдол бүхий ялгаатай утга

Үүнд эцгийн харьцангуй өндөр боловсролын түвшин (магистр буюу докторын) нь хүүхдийн доогуур нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдалтай үр дүнг илэрсэн байна, энэхүү үр дүнгийн шалтгаан тодорхойлбол магистр докторын түвшинтэй эцгийн тоо нь зөвхөн 8 хүн байх учраас сорьцын тооны хувьд хомс, үр дүнгийн талаар оновчгүй байж мэднэ. Өөрийгөө танилцуулах, гэр бүлийн байдлаа танилцуулж ярьж илтгэх чадвар сайн байгаа хүүхдийн эхчүүдийн боловсролын түвшин өндөр, үндсэн өнгө буюу завсрын өнгийг таньж нэрлэх (хүүхдийн өнгийг таних чадвар төдийгүй үгсийн сангийн баялаг эсэхийг бас шалган байцаасан) чадвар сайн байгаа хүүхдийн ээж нарын боловсролын түвшин бас харьцангуй өндөр байна гэдгийг тус судалгаагаар дамжин гэрчилсэн.

Дүгнэлт

Хүүхдийн нийгэмшихүйн сургуульд бэлтгэгдсэн байдлын хувьд эцгийн боловсролын түвшинтэй сүрэг харьцаатай байна.

Хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдал нь эхчүүдийн боловсролын түвшний хувьд бас ялгаатай байна, эхчүүдийн боловсролын түвшин өндөр болох тусам хүүхдийн танин мэдэхүйн сургуульд бэлтгэгдсэн байдал нь сайн байлаа.

Ном зүй

Hoff, E. (2003a). Causes and consequences of SES-related differences in parent-to-child speech. *Socioeconomic status, parenting and child development*. 147-160.

- Hoff, E. (2003b). The specificity of environmental influence: Socioeconomic status affects early development via maternal via maternal speech. *Child Development*. 74, 1368-1378.
- Hoff-Ginsberg, E. (1991). Mother-child conversations in different social classes and communicative settings *Child Development*. 62, 782-796.
- Ganzach, Y. (2000). Parents' education, cognitive ability, educational expectations and educational attainment: Interactive effects. *British Journal of Educational Psychology*, 70, 419-441.
- Nazli, Baydar., J. B.-G., and Frank F, Furstenberg. (1993). Early Warning Signs of Functional Literacy: Predictions in Childhood and Adolescence. *Child Development*. 64, 815-829.
- Ardila, A., Rosselli, M., Matute, E., Guajardo, S. (2005). The influence of the parents' educational level on the development of executive functions. *Dev Neuropsychol*, 28(1), 539-560. Retrieved from <https://www.ncbi.nlm.nih.gov/pubmed/15992255>. doi:10.1207/s15326942dn2801_5

The Correlation Study of Mongolian Children's School Readiness and Parents Educational Level

*Jin Ming**
Inner Mongolia, China

Abstract

In this research we applied checklist test and questionnaire to study the relationship between 5-6 years old kindergarden children school readiness in three dimension which are physical level, cognitive level and socialization level and their parents' education level. The result shows that at childrens' socialization level we found there are differences between father's education level($F=3.414, P=0.037^*$). At the cognitive level we found that there are differences between mother's education level($F=3.139, p=0.048^*$), those better educated mother's children tend to have a better cognitive school readiness.

Keywords

5-6 years old children, physical, cognitive, socialization

* Corresponding author: 563299001@qq.com